



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/011/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2026 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443

Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Албан шаардлага.....	10
3.2 Зөвлөмж.....	10
3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал	10
3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.23 № 262

танай _____ -ны № _____ -т

МӨСТ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.УУГАНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 24 дүгээр зүйлийн 24.6, 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3.1, 60.3.6, Газрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 42.3, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй 47,562.6 мянган төгрөг,
- Няравын дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээний мөнгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт дутуу, зарцуулалт тодорхойгүй 5,156.0 мянган төгрөг,
- Баримтат кино зураг авалтын дэмжлэг, сургалтын зардал гэх зэрэг урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас спортын тэмцээний зардалд нийт 1,584.0 мянган төгрөг зарцуулсан,

8426050641

- Сумын нийтийн үйлчилгээний зориулалтгүй ТҮЦ түр байгууламжийн буулгах орчныг тохижуулах ажлаас нөхөн олговор олгохдоо иргэдтэй гэрээ байгуулж нөхөн олговрын хэмжээг тохиролцоогүй,
- Мал угаалгын ванн 40 сая төгрөгөөр төлөвлөснөөс 20 саяар, соёлын төвийн сандал 75 сая төгрөгөөр төлөвлөснөөс 60.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй,
- Хээлтүүлэгч хуц 6 ширхэг, 9.0 сая төгрөгийн өртөгтэй 1000ш өвс, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж зэрэг 29,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй,
- Хогийн цэгийг хумих, хашаалах, камержуулах 126,000.0 мянган төгрөгийн ажил төсөвгүй, ажлын даалгавраар хийсэн зэрэг зөрчлүүд байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөст сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 746,474.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 13,927.5 мянган төгрөг буюу 1.9 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Тайлант онд сумын төвийн тохижилт, бүтээн байгуулалт, дахин төлөвлөлттэй холбогдуулан 10 иргэний газрыг чөлөөлөн нөхөн олговор олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,026,062.81	1,017,544.06
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	414,830.74	404,110.72
3	1.1.3 АВЛАГА	313,267.15	324,575.55
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	242,572.61	174,766.61
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	55,392.31	114,091.17
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,568,417.43	12,241,291.63
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,568,417.43	12,241,291.63
8	1.2.2.02 Биет хөрөнгө	2,455,424.37	12,128,400.35
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	112,993.06	112,891.28
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,594,480.24	13,258,835.69
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	45,810.3	63,258.98
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,810.3	63,258.98
13	2.1.1.03 Өглөг	45,810.3	63,258.98
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,548,669.94	13,195,576.71
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	3,548,669.94	13,195,576.71
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	695,532.95	0.0
17	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	695,532.95
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,198,022.5	11,844,929.26
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,114.5	655,114.5
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,594,480.24	13,258,835.69

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,897,203.09	12,164,300.35
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	797,253.7	742,069.78
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	526,074.79	556,189.44
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	544,876.69	589,702.09
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,801.9	-33,512.65
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	22,283.52	43,646.26
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	248,895.39	142,234.08
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	784,243.93	11,422,230.57
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,098,545.3
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,315,705.46	0.0

11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,952,171.11	2,570,354.95
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,952,171.11	2,570,354.95
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,899,867.6	2,461,986.87
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,856.26	901,687.82
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,372.55	114,026.76
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,255.07	211,961.78
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	575,526.54	696,024.04
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	7,942.85	182,548.8
19	1.1.2.01.1.07 Төмилөлт, зочны зардал	9,545.6	7,605.6
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,998.97	25,017.74
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	223,369.74	323,114.33
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,303.51	108,368.08
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	945,031.98	9,593,945.4
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	3,089.17
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	0.0	-3,089.17
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	945,031.98	9,590,856.24

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,143,447.47	2,472,162.79
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	797,253.7	742,069.78
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	526,074.79	556,189.44
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-18,801.9	-33,512.65
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	22,283.52	43,646.26
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	248,895.39	142,234.08
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,449.94	31,426.06
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	3,776.2	3,338.3
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	200,669.26	107,469.73
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,488.31	1,730,093.01
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	30,488.31	39,801.99
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,278,566.62
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	411,724.4
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,315,705.46	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,341,412.14	1,822,038.2

16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,341,412.14	1,822,038.2
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,288,124.23	1,698,695.12
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,918.56	899,339.11
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,859.37	119,869.62
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,301.03	212,522.75
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	46,260	27,324.51
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	447.6	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	10,910.7	9,787.8
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,545.6	7,605.6
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,309.39	43,712.12
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	127,571.98	378,533.61
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,287.91	123,343.08
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	802,035.33	650,124.59
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	541,988.4	660,844.61
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	541,988.4	660,844.61
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	541,988.4	660,844.61
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-541,988.4	-660,844.61
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000	0.0
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,000	0.0
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	210,046.93	-10,720.02
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	204,783.81	414,830.74
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	414,830.74	404,110.72

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,605,121.92	2,605,121.92
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,483.96	-1,483.96
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,603,637.96	2,603,637.96
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	945,031.98	945,031.98
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,548,669.94	3,548,669.94
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,548,669.94	3,548,669.94

7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	56,050.53	56,050.53
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,604,720.47	3,604,720.47
9	1.7 Тайлант үеийн үр дүн	9,590,856.24	9,590,856.24
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	13,195,576.71	13,195,576.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,989,341.10	1,994,792.07
11	3.1.01.1.1 Татварын орлого	729,546.60	742,069.78
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	479,902.10	556,189.44
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	513,414.80	589,702.09
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(33,512.60)	(33,512.60)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	36,300.00	43,646.26
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	213,344.40	142,234.08
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,200.00	31,426.06
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	6,244.40	3,338.30
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	161,900.00	107,469.73
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,259,794.50	1,252,722.29
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	46,874.00	39,801.99
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	801,195.90	801,195.90
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	411,724.60	411,724.40
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,514,456.60	2,006,725.86
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,585,775.70	1,506,969.26
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,532,018.10	1,398,001.17
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	959,001.80	899,339.11
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,875.20	119,869.62
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,069.00	212,522.75
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	35,097.10	26,844.51
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	-
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	16,560.50	9,787.80
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	12,524.10	7,605.60
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,317.80	41,899.67
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	99,889.40	80,132.11
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,757.60	108,968.09
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг		0.00
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	53,737.60	45,066.59
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	843,084.90	499,756.61
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	85,599.00	-
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(525,118.50)	(11,933.79)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	525,118.50	11,933.79

7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	525,118.50	11,933.79
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	397,549.42
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	385,615.63

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	67,784.54	477,370.72
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,784.54	477,370.72
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	67,784.54	477,370.72
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	67,784.54	477,370.72
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	67,784.54	477,370.72
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,784.54	458,875.62
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	67,784.54	297,787.62
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,748.24	283,412.62
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	13,051.60	480.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,909.64	1,812.447
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	25,837.00	281,120.17
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,754.98	14,375.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	8,754.98	14,375.00
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	161,088.00
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	-	161,088.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	17,281.32	18,495.097

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ын нэгтгэл хамруулан гүйцэтгэсэн ТТЗ-ын нэгтэл, ОНХС, ХХС-гийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 488,400.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 265,098.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Санхүүгийн байдлын тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 11,317.0 мянган төгрөг,
- Хугацаа хэтэрсэн зээлийн алданги, тайлант жилийн хүүгийн орлогыг тусгаагүй- 15,224.5 мянган төгрөг,
- Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй – 7,621.1 мянган төгрөг,

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүү байдлын тайлан, үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 220,520.6 мянган төгрөг,
- Мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан – 10,415.1 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил,

¹ Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 28,916.5 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 223,302.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 5,156.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 218,146.6 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Няравын дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээнд 5,156.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт дутуу, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын хоёр дугаар зүйлийн 3-д “Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ.” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

3.2 Зөвлөмж

3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, хугацаа хэтэрсэн 47,562.6 мянган төгрөгийн зээл байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.” гэж заасантай, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах ажлыг 2026 онд багтаан зохион байгуулах, зээлийн эргэцийг сайжруулах.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

3.2.2.1 Илрүүлэлт: Баримтат кино зураг авалтын дэмжлэг, сургалтын зардал гэх зэрэг урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас спортын тэмцээний зардал зэрэгт 1,584.0 мянган төгрөг гаргасан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д "орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно" 60.3.1-д "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 60.4-д "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Урсгал үйл ажиллагаанд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахгүй байх, иргэдийн санал авч эрэмбэлээгүй ажлыг төлөвлөхгүй байх.

3.2.2.2 Илрүүлэлт: Сумын нийтийн үйлчилгээний зориулалтгүй ТҮЦ түр байгууламжийг буулгах орчныг тохижуулах ажлаас нөхөн олговор олгохдоо иргэдтэй гэрээ байгуулж нөхөн олговрын хэмжээг тохиролцоогүйгээр 13,200.0 мянган төгрөг олгосон нь Газрын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 42.3-д "Энэ хуулийн 42.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нөхөх олговортойгоор газрыг чөлөөлж байгаа тохиолдолд иргэн аж ахуйн нэгжтэй гэрээний үндсэн дээр нөхцөлийг тохиролцох, аливаа маргаантай асуудал гаргахгүй байх.

3.2.2.3 Илрүүлэлт: Мал угаалгын ванн 40 сая төгрөгөөр төлөвлөснөөс 20 саяар, соёлын төвийн сандал 75 сая төгрөгөөр төлөвлөснөөс 60.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүйг харуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцоо судалгаанд үндэслэн төсвийг төлөвлөх. Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөх.

3.2.2.4 Илрүүлэлт: Мал угаалгын ванн, цэцэрлэгийн камержуулалт зэрэг төсөл арга хэмжээнүүдэд гүйцэтгэлийн баталгаа 1, 2 сар байхаар гэрээнд тусгасан нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна", 14.6-д "Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна. **Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжид заасны дагуу барьцаа авч, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын чанарт анхаарах.

3.2.2.5 Илрүүлэлт: Хээлтүүлэгч 6 тооны хуц , 9.0 сая төгрөгийн 1000 ш өвс, ЖДҮ-ийг дэмжих тоног төхөөрөмж зэрэг 29,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-д

"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг эхний хагас жилийн тайланд бүртгэх.

3.2.2.6 Илрүүлэлт: Хогийн цэгийг хумих, хашаалах, камержуулах ажил нь төсөвгүй, ажлын даалгавраар хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ"-г санхүүжүүлэхийг хориглоно гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль бусад хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан /зураг төсөл, төсөв, бусад/ төсөл арга хэмжээг төлөвлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Санхүү байдлын тайланд авлага дутуу бүртгэсэн	1	11,317.0	1	11,317.0			1	11,317.0				
Хоршоо хөгжүүлэх сан	Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан	1	15,224.5			1	15,224.5	1	15,224.5				
Хоршоо хөгжүүлэх сан	Мөнгөн гүйлгээний тайланд орлого зарлагыг дутуу бүртгэсэн	1	7,621.1	1	7,621.1			1	7,621.1				
Орон нутгийн хөгжлийн сан	Мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан	1	10,415.1			1	10,415.1	1	10,415.1				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү байдлын тайлан, үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1	220,520.6			1	220,520.6	1	220,520.6				
ДҮН		5	265,098.3	2	18,938.1	3	246,160.2	5	265,098.3				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Орон нутгийн хөгжлийн сан	Няравын дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээний мөнгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт байхгүй хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй	1	5,156.0			1	5,156.0						

	Баримтат кино зураг авалтын дэмжлэг, сургалтын зардал гэх зэрэг урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас спортын тэмцээний зардал гаргасан	1	1,584.0					1	1,584.0		
	Сумын нийтийн үйлчилгээний зориулалтгүй түц, түр байгууламжийн буулгах орчныг тохижуулах ажлаас нөхөн олговор олгохдоо иргэдтэй гэрээ байгуулж нөхөн олговрын хэмжээг тохиролцоогүй	1	13,200.0					1	13,200.0		
	Мал угаалгын ванн 40 сая төгрөгөөр төлөвлөснөөс 20 саяар, соёлын төвийн сандал 75 сая төгрөгөөр төлөвлөснөөс 60.5 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй	1	-					1	-		
	Мал угаалгын ванн, цэцэрлэгийн камержуулалт зэрэг төсөл арга хэмжээнүүдэд гүйцэтгэлийн баталгаа 1, 2 сар байхаар гэрээнд тусгасан	1	-					1	-		
	Хээлтүүлэгч хуц бш, 1000ш 9.0 сая төгрөгийн өвс, ЖДҮ-ийг дэмжих тоног төхөөрөмж зэргийг ЗДТГ-ын балансад бүртгээгүй	1	29,800.0					1	29,800.0		
	Хогийн цэгийг хумих, хашаалах, камержуулах ажил төсөвгүй, ажлын даалгавраар хийсэн	1	126,000.0					1	126,000.0		
Хоршоо хөгжүүлэх сан	Зээлийн үлдэгдлийг барагдуулаагүй, хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй,	1	47,562.6					1	47,562.6		
ДҮН		8	223,302.6			1	5,156.0	7	218,146.6		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		